

## АТРЫН ГУРАВДУГААР АЯН, ОНЦЛОГ, ҮР ДҮН

Б.ПУНСАЛДУЛАМ

**Товч агуулга:** Атрын гуравдугаар аян Монгол улсад өмч хувьчлал явагдсны дараа өрнөснөөрөө өмнөх хоёр аянаас ялгагдаж байв. 1990 оноос газар тариалангийн үйлдвэрлэл буурсаар хүн амын хүнсний хэрэгцээгээ хангаж ирсэн өмнөх аянуудын ололт амжилт, хүрсэн үр дүн алга болж гадаадаас импортлох болжээ. Энэ нөхцөлд Монгол улсын төрөөс 2008 онд атрын гуравдугаар аяныг 3 жилийн хугацаатай өрнүүлэн, улмаар цааш хугацаа сунган зохих арга хэмжээг хэрэгжүүлж иржээ.

**Түлхүүр үг:** Атрын аян, зах зээл, агротехник, газар тариалан

Монгол орны газар тариалангийн байдал, түүнийг дэмжсэн бодлого, хөтөлбөрүүд 1990 оноос хойшх Монгол улсын төрөөс газар тариалангийн талаар баримталж ирсэн бодлого, түүний хэрэгжилтийг дараах үе шатад авч үзэж болохоор байна. Үүнд:

1. 1998-2005 онуудад газар тариалангийн үйлдвэрлэлийг олон төсөл хөтөлбөрийн хүрээнд дэмжсэн
2. 2006-2011 онуудад газар тариалан хөгжүүлэх Үндэсний хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлсэн
3. 2012-2015 онуудад “Атрын аян-III” үндэсний хөтөлбөрийг үргэлжүүлэн өрнүүлсэн
4. 2016-2019 онуудад төрөөс ХАА-г хөгжүүлэх үндэсний хэмжээний цогц хөтөлбөрүүдийг боловсруулан, хэрэгжүүлсэн байна.

Монгол улсын газар тариалангийн үйлдвэрлэл ХХ зууны 60,70,80-аад оны хэмжээнд хүрч чадахгүй байв. 2005 оны байдлаар аж ахуйн нэгжүүд 77031 мянган тн улаан буудайн ургац авсан нь 1956 оны үеийн ургацын хэмжээнд хүрч байв. Мөн оны байдлаар 188,9 мянган га-д тариалж, 148,7 мянган га-д уринш хийж нийтдээ 337,6 мянган га-д үйлдвэрлэл явуулсан нь ашиглаж болох талбайн

дөнгөж 28,1 хувийг эзэлж байв. Монгол улс жилдээ 240,0 мянган тн гурил, 129.0 мянган тн төмс, 173.0 мянган тн хүнсний ногооны хэрэгцээ шаардлагатай бөгөөд энэ хэмжээний газар тариалангийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд 800.0 орчим мянган га эргэлтийн талбай шаардлагатай ажээ.

2005 оны байдлаар сүүлийн 10 жилийн Монгол орны экосистемийн шинж үзүүлэлтийг 1980-1990 онтой харьцуулбал ургацын бууралт 60-80 хувь, хог ургамлын тархалт 40-80 хувь, хортны тархалт 10-20 хувь, бэлчээрийн ургац 4-6 дахин буурч зарим бүс нутгийн бэлчээрийн даац 2-3 дахин хэтэрч, агроэко систем сүйрлийн байдалд хүрсэн байна. Сүүлийн 30 жилд үзэгдээгүй их ган 2000-2002 онд тохиолсон бол, 2005 оны 6-8 сардууд сүүлийн 50 жилд болоогүй үргэлжилсэн их халуун болжээ. Сүүлийн 3 жилийг өмнөх 10 жилтэй (1985-1995 онтой) харьцуулбал уриншийн эцсийн чийг 20-30 хувиар буурч, уриншийн 50-100 см гүний залгамж буюу амь чийг багасаж чийгийн хуримтлал зөвхөн 1-50 см гүнд зонхилон явагдах болсон нь уриншийн ач холбогдлыг бууруулж, тариа богино хугацаанд гандан хатах үндэс шалтгаан болжээ. Мөн хөрсийг хагалж, олон дахин механик элдэншүүлэлт хийж байгаагаас хөрсний элэгдэл эвдрэл явагдаж, тариалангийн нийт талбайн хөрсний 96,8 хувь нь элэгдэл эвдрэлд өртсөний 12,4 хувь хүчтэй эвдрэлд орсон хөрстэй болжээ. Үүний уршгаар тариалангийн үндсэн нутгууд түүний дотор Сэлэнгэ аймгийн Баруунхараа, Зүүнхараа, Сайхан, Баруунбүрэн, Орхон, Хушаат, Шаамар, Баянхараат, Дархан-Уул аймаг бүхэлдээ, Төв аймгийн Жаргалант, Цээл, Угтаал зэрэг газруудад тариалан бэлчээрийн талбай илүү элэгдэл эвдрэлд орж зарим газар цөлжилт голомт хэлбэрээр явагдсан байна. Хөрсний чийг хангамж агааржилтын түвшинтэй уялдан микробиологийн идэвх эрчимжиж байгаагаас үр тариа уриншийн 3 талбайт сэлгээнд жилд дунджаар 0.4-1.5 т/га ялзмаг эрдэсжиж байна. Үүний уршгаар сүүлийн 40 гаруй жилд хөрсний ялзмагийн агуулалт 37-52 хувь буурчээ. Өөрөөр хэлбэл шим тэжээлийн энерги багасаж өөрийгөө хамгаалах, зохицуулах чадвар нь суларч байгаагаас гадны тохиромжгүй нөлөөнд таримал нэн эмзэг өртөмтгий болсон байна<sup>1</sup>.

Хүйтрэлгүй хоногийн тоо уртсах хандлагатай байгаагаас үр тарианы эртний болцтой сортуудын ургац буурч харин дунд ба дунд оройн болцтой сортуудын ургац нэмэгдэх хандлагатай байна. Дулааралтын эрчим цаашид өсөж ирэхэд, эрдэмтдийн тооцоолсноор агаарын дундаж температур нэг хэмээр нэмэгдэхэд уур амьсгалын бүс 200-300 км-ээр хойшилно хэмээн үзэж байна. 2050 он гэхэд өндөр уулын тундр тайгын бүсийн талбай 4-14 хувь, ойт хээрийн талбай 7 хувиар багасаж,

<sup>1</sup> МУУТА. Х-15,Д-5, ХН-350. т.20

харин хээрийн бүс, ойт хээрийг шахан хойш шилжин, цөлийн бүс их нууруудын хотгор хүртэл түрж талбай 18 хувь нэмэгдэх төлөвтэйг судлаачид анхааруулж байна. Бүсийн өөрчлөлт явагдаж байгаа нь одоо ч гэсэн мэдэгдэж байна. Гэтэл мөрдөж байгаа тариалангийн технологи бүс нутгийн хэмжээнд боловсрогдсон, тариаланчид түүнийг тоймлон хэрэглэж заншсан учраас цаг уурын нөхцөл богино зайд, орон нутгийн хэмжээнд огцом өөрчлөгдөх болсон энэ цаг мөчид тэр бүр таарахгүй байна. Төв, Сэлэнгэ, Булган, Дархан-Уул аймгийн сүүлийн жилүүдийн газар тариалангийн байдлыг харьцуулахад 2002-2004 онд Төв аймагт үр тариа тариалсан талбай 53,4 хувь, Дархан-Уул аймагт 41,0 хувь, Сэлэнгэ аймагт 39,8 хувиар буурч, нэгж талбайн ургац дээрхи дарааллаар 7.0ц/га, 6.5 ц/га, 7.6 ц/га байгаа нь эдийн засгийн ашигт төвшингээс бага байна. Харин Төв аймгийн Цээл, Сэлэнгэ аймгийн Цагааннуур, Хүдэр, Ерөө, Алтанбулаг зэрэг сумдын дундаж ургац арай өндөр байна<sup>2</sup> хэмээн тухайн нөхцөл байдлыг судлаачид тодорхойлон тэмдэглэжээ.

Тариалангийн төв бүсийн үр тарианы үйлдвэрлэлийн байдал (2002-2004)

| Аймаг   | Үр тариа тариалсан талбай |        |       | 2002-2004 онд талбайн бууралт |      | Нэгж талбайн ургац ц/га |      |      |        |
|---------|---------------------------|--------|-------|-------------------------------|------|-------------------------|------|------|--------|
|         | 2002                      | 2003   | 2004  | га                            | хувь | 2002                    | 2003 | 2004 | дундаж |
| Төв     | 47529                     | 23734  | 22163 | 25366                         | 53.4 | 3.4                     | 9.0  | 8.7  | 7.0    |
| Сэлэнгэ | 122906                    | 100389 | 74001 | 48905                         | 39.8 | 3.0                     | 11.1 | 8.7  | 7.6    |
| Булган  | 29580                     | 28959  | 22580 | 7000                          | 32.7 | 9.1                     | 7.3  | 8.8  | 8.4    |
| Дархан  | 14616                     | 13598  | 8638  | 5978                          | 41.0 | 3.9                     | 8.2  | 7.5  | 6.5    |

Тус улс 2003-2007 онд жилд дунджаар 116.4 мянган тн буудай хураан авч 78.0 мянган тн-оор гурил үйлдвэрлэн нийлүүлж, зээл тусламжаар 27,7 мянган тн буудай авч хүнсний хэрэгцээгээ хангаж байв. Өөрсдийн улаан буудайгаар үйлдвэрлэсэн гурил нь улс орны хүнсний хэрэгцээний дөнгөж 24,9 хувийг хангаж байв.<sup>3</sup>

2007 оны байдлаар усалгаатай нийт талбайн хэмжээ 22.0 мянган га байгаа бөгөөд үүний 5.0 мянган га-д буудай тариалж дунджаар 19,8 цн, усалгаагүй талбайд тарьснаас 2,1 дахин их ургац авч байв. Хэрэв усжуулах технологийг боловсронгуй болгох, бордож тордох, усалгаанд тохирсон сорт тариалах, ургамал хамгаалах арга хэмжээг оновчтой болгож чадвал авах ургацыг наад зах нь 30 цн га-д хүргэж болохыг судалгаа харуулж байв. Сүүлийн жилүүдэд манайд гаргасан халуунд тэсвэртэй, зохицох чадвар сайтай Халх гол-1, Дархан-34, Дархан-74, сорт Сэлэнгэ

<sup>2</sup> МУУТА. Х-15. Д-5. ХН-350. т.3

<sup>3</sup> МУУТА. Х-15. Д-5. ХН.465. т.1

Булган Хэнтий Хөвсгөл аймгийн 38 аж ахуй нэгжүүдэд амжилттай тариалж байна. 2007 оны мэдээгээр ашиглаж буй нийт эргэлтийн талбай 342,7 мянган га байгаагаас 146,7 мянган га-д уринш, 196,0 мянган га-д тариалалт хийсэн байна<sup>4</sup>.

1980-аад оноос газар тариаланд хөрсийг эргүүлэхгүйгээр хавж боловсруулах, талбайн гадаргуунд хучлага үүсгэх замаар салхины элэгдээс хамгаалах, чийгийн алдагдыг бууруулахгүй зориулалтын техникийг хэрэглэж, хөрсийг хавж боловсруулах технологийг нэвтрүүлснээр 1982-1991 ондуудад улсын дунджаар 10-14 цн/га үр тариа хурааж байв.

#### Монгол орны тариаланд хэрэглэх хөрс элдэншүүлэх технологийн чиглэл

|   | Технологи                           | Технологийн онцлог   | Үндсэн параметр   |
|---|-------------------------------------|--|---|
| 1 | Боловсруулалтыг цомтгосон технологи | Гүнийг багасгах, механик элдэншүүлэлтийн тоог цөөлж, технологийн үйлдлийг аль болох хамтатган хийх | Чийг хуримтлал нэмэгдэн бүтэц сайжирч, задрал багасна.  |
| 2 | Хавж элдэншүүлэх технологи          | Анжис хэрэглэхгүй, хавагч багаж, гербицит хэрэглэж талбайн гадаргуунд сүрлэн бүрхэвч үлдээх        | - Сүрлийн 15-20% үлдэж, хийсгэлтийг 30-50% багасгана.<br>- Хагалсантай харьцуулбал чийгийн хуримтлал 5-10% нэмэгдэж, ууршилт 5-8% багасна.<br>- Зардал 15-20% багасан, ургац 5-10% нэмэгдэнэ  |
| 3 | Механик элдэншүүлэггүй технологи    | Тариалалтын үед зүсэж буй нарийн мөрөөс өөр механик боловсруулалт хийхгүй                          | - талбайн гадаргуунд сүрлэн хучилга тогтож элэгдэл зогсоно.<br>- хавсантай харьцуулбал чийгийн ууршилт 40% багасан, өнгөн үеийн чийг нэмэгдэж тарих үрээ нимгэн /4-5см/ суулгах нөхцөл бүрдэнэ.<br>- агроэкоосистем бүхэлдээ тогтворжиж ургац 10-15% нэмэгдэнэ. |

Газар тариаланд эрдэс ба шим бордоог системтэй хэрэглэснээр үржил шимийг сайжруулах төдийгүй үр тарианы ургацыг нэмэгдүүлэх бүрэн боломжтой байдаг. 1975-1994 онд газар тариалангийн үйлдвэрлэлд нэг жилд 90-97 мянган тн эрдэс, 200-300 тн шим бордоо хэрэглэж байсан нь тариалангийн 1 га талбайд дунджаар 27,6 кг N, P, K оногдож байсан бол 2000-2005 онуудад эрдэс бордооны олноо бага, үнэ өндөр (1 тн шивтрийн шүү 240,0 \$, давхар суперфосфат 249,9 \$, хлорт кали 187 \$) байгаагаас тариалан эрхэлдэг аж ахуй нэгжүүд бордоог технологийн дагуу

<sup>4</sup> МУУТА. Х-15. Д-5.ХН-465. Т.15.

хэрэглэж чадахгүйд хүрчээ. Энэ нь шим тэжээлийг эргүүлэн нөхөж өгөх хуулийг зөрчиж байв.

### **Атрын гуравдугаар аяныг явуулах нөхцөл боломж, шаардлага, зорилт**

Монгол орны нийгэм эдийн засаг, гадаад дотоод хүчин зүйл, байгаль орчны нөлөөлөл зэрэг олон нөхцөл шалтгаан, шаардлагын улмаас Монгол улсын засгийн газрын 2008 оны 70 дугаар тогтоолоор “Атрын III аян” тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөрийг боловсруулан гаргаж, газар тариалангийн үйлдвэрлэлийг эрхлэх эрх зүйн болон эдийн засгийн таатай орчинг бүрдүүлэх, тариаланчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, мэргэжилтэй ажилтан бэлтгэх, өнжсөн талбайг эргэлтэд оруулах замаар тариалах талбайн хэмжээг нэмэгдүүлэх, дэвшилтэд техник технологи нэвтрүүлж газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх зорилт дэвшүүлжээ.

“Атрын аян-III” тариалангийн үндэсний хөтөлбөрийг зөвхөн нийгэм эдийн засгийн шаардлагын дагуу явуулсан үйл явц биш байв. Энэхүү аяныг өрнүүлэх нөөц боломж Монгол улсад бүрдсэн хэмээн үзсэн учраас зохион байгуулсан юм. Тус улсын газар тариалангийн салбарт оруулсан хөрөнгө оруулалт нэмэгдэж, материаллаг бааз суурь тодорхой хэмжээнд тогтворжсон байна. Газар тариалан хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг улсын төсөв, аж ахуйн нэгжийн хөрөнгө, банкны зээлийн хүрээнд шийдэхийн зэрэгцээ НҮБ-ийн Хүнс, Хөдөө Аж Ахуйн Байгууллага, Япон улсын Засгийн газрын буцалтгүй тусламжтайгаар хэрэгжиж буй КР-1, КР-2 төслийн хуримтлалын сан, Хятадын тусламжийн сан гэх мэт гадаадын доноруудаас зохих хэмжээний хөрөнгө санхүүгийн дэмжлэг техникийн туслалцаа авч үйл ажиллагааг явуулсан байна.

Атрын гуравдугаар аян шинээр атар газар хагалах зорилтыг тавиагүй бөгөөд хөтөлбөрийн хүрээнд шинээр атар газар хагалахыг хориглож байв. Тариалангийн талбайг эргэлтэд оруулах, эзэмшилт ашиглалтад нь хяналт тавих үүргийг хуулиар сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, засаг дарга, газрын асуудал хариуцсан алба, мэргэжилтнүүд хариуцаж байв. Өөрөөр хэлбэл тухайн сум багийн иргэд хяналт тавих бололцоотой нөхцөлийг хуулиар олгосон. Мөн аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Засгийн газар ерөнхий хяналтыг хэрэгжүүлж байв.

Атрын аяны хөтөлбөрийн хүрээнд 250.000 мянган га өнжсөн талбайг эргүүлэн ашиглаж, тариалах талбайгаа 306.000 мянган га-д хүргэж улаан буудайн тариалан 420.000 мянган тн ургац хураан авч, дотоодын хэрэгцээгээ хангах зорилт дэвшүүлж, дараах гурван зарчмыг баримтлахаар тогтсон байна. Үүнд:

- Атрын аян-III тариалан хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг төрийн болон мэргэжлийн байгууллагын дэмжлэгтэйгээр иргэд хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд хэрэгжүүлнэ.

- Экологийн тэнцвэрт байдлыг хамгаалах, шинээр нэмж атар газар хагалахгүй.

- Хөрөнгө зардлыг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах техник, технологийг дэвшлийг бүтээлчээр ашиглана. Дээрх зарчмын дагуу газар тариалан хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд

- Монголын нийт тариаланчдыг жижиг том гэж ялгахгүй хүүгийн хөнгөлттэй нөхцлөөр зээлд хамруулах, үрийн дэмжлэг үзүүлэх, хураан авсан ургацад урамшуулал олгох, трактор, комбайн, ХАА-н бусад техник тоног төхөөрөмжийг хөнгөлттэй нөхцлөөр өгөх, эзэмшүүлэх

- Сумын хэмжээнд тоног төхөөрөмж ажиллуулах технологийн зөвлөгөө өгөх үүрэг бүхий мини агропарк байгуулан түүгээр дамжуулан өрхийн тариалан эрхэлж буй жижиг аж ахуйн нэгжүүдийн захиалга хүсэлтийн дагуу үйлчлэх

- Хүнс, ХАА-н чиглэлийн төрөл бүрийн үйлдвэр эрхлэх талаар сургалтад хамруулж хүлэмж, хамгаалагдсан хөрсний тариалан, амьтан ургамлын гаралтай хүнсний бүтээгдхүүн боловсруулах үйлдвэр эрхлэх зэрэг шинэ технологи арга ажиллагаа эзэмшихэд дэм болох гарын авлага материалаар хангах, сургалт зохион явуулах

- Тариалан хөгжлүүлэх үндэсний хөтөлбөр дэлхийн дулаарал, хуурайшилт зэрэг уур амьсгалын өөрчлөлт, байгаль экологийн тэнцвэрт бадал, хөрснийг эвдрэл гэмтлээс хамгаалах тариалан эрхлэх арга технологийг шинэчилж, дэвшилт техник, технологи нэвтрүүлж эрчимжүүлэх хамгаалагдсан хөрсний болон усалгаатай тариалангийн хэмжээг нэмэгдүүлэх, үр үржүүлгийн төвийг байгуулах

- Байгальд ээлтэй технолги нэвтрүүлэх, үүний тулд хөрсний үржил шимийг дээшлүүлэх, нэг га-гаас авах ургацыг нэмэгдүүлэх зорилгоор байгалийн фосфоритоос механик химийн технологийн байгалийн цэвэр идэвхжүүлсэн фосфорын ба азот фосфорын холмитог үрлэн бордоо үйлдлэх технологийг гаргах ба уг бордоог газар тариаланд хэрэглэх заавар зөвлөмж боловсруулах, тариалангийн гаралтай болон хүнсний бүтээгдхүүний аюулгүй байдлыг тодорхойлох үндэсний лавлагаа лаборатор байгуулах зэргээр олон талт үйл ажиллагааг явуулахыг зорьж байв.

**Атрын гуравдугаар аяны хүрээнд хийгдсэн ажлууд**

“Атрын аян-III” тариалангийн үндэсний хөтөлбөрийн эхний жил буюу 2008 онд 153,9 мянган га-д буудай, 11,5 мянган га-д төмс, 7.0 мянган га-д хүнсний ногоо, 5.0 мянган га-д тэжээлийн ургамал, нийтдээ 177,4. мянган га-д тариалж 187.0 тн буудай, 123.0 мянган тн төмс, 91.0 мянган тн хүнсний ногоо хураан авах боломж бүрдэж хэрэгцээт төмсний 96 хувь, хүнсний ногооны 53,0 хувь, гурилын 45,0 хувийг хангахаар тооцон төлөвлөсөн байна. Хаврын тариалалтад нийтдээ 24,9 мянган тн буудайн үр шаардлагатайгаас тариалан эрхлэгч аж ахуй нэгж, байгууллага, иргэд 13,1 мянган тн үр нөөцөлсөн бөгөөд түүн дээр улсын нөөцийн газрын 3,5 мянган тн, Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2,5 мянган тн үрийг тус тус нэмж тооцвол 19,1 мянган тн үрийн буудайн нөөц бүрдэж 5,8 мянган тн үр дутагдах тооцоо хийжээ. Дутагдах 5,8 мянган тн үрийг импортоор нийлүүлэх тендер зарлан дүгнэж ОХУ-аас манай оронд нутагшсан “Бурядская остистая-79”, Бурядская-79” сортын үр 2000 тн, “Сэлэнгэ” сортын үр 1000 тн, Алтайский -50 сортын үр 3000 тн нийтдээ 6000 тн үрийг 5 дугаар сарын 1-ны дотор нийлүүлэхээр ажилласан байна. Дотоодын нэг тн үрийн буудайн үнийг 400.0 мян төгрөгөөр тооцож, 20 хувийн урьдчилгаа олгож, 2008 оны ургацаас нөхөн бүрдүүлэхээр болсон байна. Тариалалт, уринш боловсруулалт, ургац хураалт хадлан тэжээл бэлтгэлийн ажилд нийтдээ 20,2 мянган тн дизель түлш шаардагдах тооцоо гарч, үүнээс тариалатад 6,2 мянган тн дизель түлш хэрэглэх тооцоо гаргажээ<sup>5</sup>.

Газар тариалан хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрх зүйн таатай орчныг бүрдүүлэхийн тулд “Газрын тухай хууль”-ийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Монгол улсын Засгийн газрын 2003 оны 28 дугаар тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулж үр тарианы үйлдвэрлэл эрхэлж буй аж ахуйн нэгж, иргэний эзэмших талбайн дээд хэмжээг улаан буудай тариалах талбайг 20.0 мянган га, төмс, хүнсний ногооны талбайн хэмжээг 200 га хүртэл нэмэгдүүлэхээр шийдвэрлэжээ. Харин энэ аяны хүрээнд тариалангийн газартай болох хүсэлтэй иргэд (Улсын нэгдмэл сангийн 2007 оны тайланд 472.5 мянган га атаршсан газар бүртгэгдсэн) энэхүү газраас эзэмших хүсэлтээ “Газрын тухай хууль”-ийн 32 дугаар зүйлд заасны дагуу тухайн шатны Засаг даргад батлагдсан загварын дагуу гаргана. Иргэдэд эзэмшүүлэх газрын хэмжээг 2002 оны №28 тоот тогтоолоор баталсан. Давуу эрхээр эзэмшүүлэх газрын хэмжээ нь үр тарианы зориулалтаар 100 га хүртэл, төмс хүнсний ногооны зориулалтаар 5 га хүртэл байхаар тусгасан байна. Газар тариалангийн салбарт 3-аас доошгүй жил ажилласан, ургацын борлуулалтаас

<sup>5</sup> МУУТА. Х-15, Д-5, ХН-467. т.55



үндсэн орлогоо олж байгаа, энэ салбарт өмнө нь 3-аас доошгүй жил ажилласан иргэн, аж ахуй нэгж хүсэлт гаргасан бол Засгийн газраас тогтоосон журмын дагуу давуу эрхээр эзэмшүүлж болно. Газар эзэмших хугацаа Монгол улсын иргэн аж ахуй нэгж 15-60 жил хүртэл хугацаатай, газар эзэмших эрхийн гэрчилгээг сунгах хугацаа нэг удаад 40 жилээс илүүгүй хугацаатай байхаар заасан байна. Гадаадын иргэд, харьяалалгүй хүн, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн байгууллага тус улсад тариалангийн газар эзэмших эрх олгоогүй бөгөөд тариалангийн газар эзэмших эрхийн гэрчилгээг зөвхөн Монгол улсын иргэн, аж ахуй нэгж байгууллагад олгохоор хуульд тусгаж өгчээ. Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй гадаадын иргэн, аж ахуй нэгж байгууллага, хуулийн этгээд газар ашиглуулсан Монгол улсын иргэн, аж ахуй байгууллагын газар эзэмших ашиглах эрхийг цуцалж ашиглалтын явцад учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр хуульд заасан байна.

“Тариалангийн тухай хууль”, “Үрийн тариалангийн даатгалын тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулах, газар тариалангийн үйлдвэрлэлд ашиглах техник, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, услалтын системийн тоног төхөөрөмж, ургамал хамгааллын бодис бордоог гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас / НӨАТ/ чөлөөлөх тухай хуулийн төсөл боловсруулан оруулж батлуусан байна. Үрийн тариалангийн даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах Гурилын үйлдвэрүүд, Улсын нөөц, Тариалан дэмжих санд тушаасан улаан буудайд жил бүр зах зээлийн борлуулалтын дундаж үнийг харгалзан мөнгөн урамшуулал олгох, улаан буудай тариалсан иргэд, аж ахуйн нэгжийн тухайн жилд тариалсан талбайн 10-20-ийг даатгахад шаардагдах хөрөнгийг төр хариуцаж байхаар “Тариалангийн тухай хуульд” нэмэлт өөрчлөлтүүд оруулжээ.

Газар тариалан эрхлэж буй аж ахуй нэгж, иргэдэд юуны өмнө тариалангийн талбайн тодорхой хэсгийг усалгаатай болгох, техник тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх зэрэгт хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ үржүүлж гаргасан чанар сайтай сортын үрийг нь улс шууд худалдан авах боломжийг бүрдүүлэх арга хэмжээг авсан байна. Гаднаас импортоор оруулж буй үрийн чанарт анхаарч, тус улсын цаг уур, бүс нутагт тохиромжтой нутагшсан Бурядский-79, Сэлэнгэ, Алтайский-50 зэрэг сортын элит болон 1 ба 2 дугаар үеийн үрийг импортоор авч үрийн чанарыг сайжруулах стратеги барин ажиллажээ. Түүнчлэн усалгаатай тариаланд тохиромжтой Дарханы УГТЭШХ үржүүлэгдэж буй “Юнцо”, Увс аймгийн эрдэм шинжилгээний салбарт үржигдэж буй “Цагаан дэглий” сортыг нэмэгдүүлэхэд анхаарсан байна. Аяны хүрээнд үр



үржүүлгийн төвийг Дархан Уул аймаг дахь Ургамал газар тариалангийн сургалт эрдэм шинжилгээний хүрээлэнд түшиглэн байгуулахаар төлөвлөж, Монгол орны тариалангийн бүс нутагт тохирсон арвин ургацтай ганд тэсвэртэй, усалгаанд тохирсон сортын үрийг үржүүлэх элит үрийн хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх зорилго тавин ажиллажээ.

Үндэсний хөтөлбөр нь хэдийгээр стратегийн бүтээгдэхүүн болох улаан буудайн үйлдвэрлэлд түлхүү дэмжлэг үзүүлэхээр заасан боловч төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн дотоодын хэрэгцээгээ өөрийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангах, хүнсний чанарыг сайжруулах нь хөтөлбөрийн салшгүй нэг хэсэг байв. Хөх тариа, арвай, хошуу будаа нь манай орны уламжлалт тарималууд бөгөөд тариалангийн сэлгээнд маш чухал тул үндэсний хөтөлбөрийн техникийн шинэчлэлд хамрагджээ. Мөн рапсыг шинэчилсэн зөвлөмжөөр усалгаатай тариалангийн сэлгээний тарималд оруулсан тул тариалсан аж ахуй нэгжүүд хөтөлбөрт хамрагдах боломж бүрдсэн байна.

Түүнчлэн тариаланд хэрэглэж буй гербицидын нөлөөлөл болон бусад химийн бодисын үлдэгдэл нянгийн бохирдлын зэргийг тодорхойлох чадавхийг сайжруулахын тулд аливаа бодисын үлдэгдэл шалгах, хянан баталгаажуулах лабораторын чадавхийг нэмэгдүүлэх асуудлыг 2008 онд шийдвэрлэхээр “Хүнсний хангамж аюулгүй байдлын жил”-д хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөгөөнд тусган ажиллажээ. Энэ хүрээнд БНСУ Засгийн газрын тусламжаар малын гаралтай хүнсний бүтээгдхүүний аюулгүй байдлыг тодорхойлох лабораторын чадавхийг бэхжүүлэх төслийг хэрэгжүүлсэн байна. Үүний хамт тариалангийн гаралтай хүнсний бүтээгдхүүний аюулгүй байдлыг тодорхойлох болон хүнсний аюулгүй байдлыг үндэсний лавлагаа лаборатор байгуулах асуудлыг судлан боловсруулсан байна.

Ийнхүү тооцоо судалгаа хийж, зохих дэмжлэгийг үзүүлснээр зөвхөн 2008 онд 180,0 мян га талбайг боловсруулан тариалалт хийх, 800-1000 га-д төмс тарьж хураах, 41,6 мян м<sup>2</sup>/ кв талбайд хамгаалагдсан хөрсний тариалан эрхлэх, 10.4 мян тн-ын багтаамжтай төмс, хүнсний зоорь шинээр барих, жилдээ 1500 тн хүнсний ногоог үйлдвэрийн аргаар, эрүүл ахуйн шаардлага хангасан нөхцөл нөөшлөх боломж бүрдүүлж, 2008 онд газар тариалангийн салбарт 4000 гаруй механикжуулагч ногоочид тогтмол ажлын байраар хангагдаж үр тариа, төмс хүнсний ногоо, жимс жимсгэний үйлдвэрлэл 20 орчим хувь өссөн байна. Газар тариалан хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 24,0

тэрбум төгрөгийн хөрөнгөөр 120 морины хүчтэй 50 ширхэг дугуйт трактор, сийрүүлэгчийн хамт, 155-180 морины хүчтэй трактор 170 ширхэг, үр тарианы комбайн 40 ширхэг, хөдөө аж ахуйн чиргүүл дүүжин машин 160 ширхэг, 25-30 морины хүчтэй 80 ширхэг тракторыг төмсний иж бүрдлийн хамт, 18-20 морины хүчтэй 455 ширхэг иж бүрдэл бага оврын тракторыг тус тус худалдан авч аж ахуй нэгжүүдэд нийлүүлжээ. Энэхүү тоног төхөөрөмжийн үнийг 50 хувиар хөнгөлж, 10 хувийн урьчилгаатай олгож, 2009-2012 оны ургацаас төлбөрийг барагдуулахаар гэрээ хийж хуваарилжээ.

### Атрын гуравдугаар аяны хүрсэн үр дүн

Атрын аян-III газар тариалангийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлсэн он жилүүдийн тариалсан талбайг улсын нэгдсэн дүнгээр үр тариа, төмс, буудай, хүнсний ногоо, тэжээлийн ургамал гэсэн төрлөөр аян эхлэхээс өмнөх он буюу 2007 он, аяны дараах 2011,2012, 2013 оноор харъя<sup>6</sup>.

| Төрөл     | 2007      | 2008      | 2009      | 2010      | 2011      | 2012      | 2013      |
|-----------|-----------|-----------|-----------|-----------|-----------|-----------|-----------|
| Үр тариа  | 121,777   | 153,951.3 | 252,381.8 | 259,196.7 | 299,927.4 | 306,234.8 | 293,261.8 |
| Буудай    | 116,650.6 | 150,016.7 | 248,907.6 | 250,232.5 | 291,350.1 | 297,318   | 275,554.3 |
| Төмс      | 11,461.5  | 12,291.5  | 13,524    | 13,813.7  | 15,375.6  | 16,820.74 | 15,503.2  |
| Хүнсний   | 6,134.5   | 6,409.5   | 6,517.9   | 7,032.2   | 7,793     | 7,854.19  | 8,311.3   |
| Тэжээлийн | 4,939.4   | 5,549.6   | 3,305.0   | 11,133.2  | 10,874    | 13,783.61 | 14,390.4  |

Монгол Улсын Үндэсний статистикийн хороо. /Хэмжих нэгж га-гаар/

### Нэг га-гаас хураасан ургац. /Улсын хэмжээгээр/

| Төрөл    | 2007 | 2008  | 2009  | 2010  | 2011  | 2012  | 2013  | 2014  |
|----------|------|-------|-------|-------|-------|-------|-------|-------|
| Буудай   | 9.4  | 14    | 15.6  | 13.8  | 15    | 15.6  | 13.4  | 16.8  |
| Төмс     | 99.8 | 109.6 | 111.8 | 121.6 | 131.1 | 146.2 | 123.6 | 122.3 |
| Үр тариа | 9.4  | 13.8  | 15.5  | 13.7  | 14.9  | 15.7  | 13.2  | 16.5  |

Монгол Улсын Үндэсний статистикийн хороо. /Хэмжих нэгж цн./

### Тариалсан талбай

|                       | 2006  | 2007  | 2008  | 2009  | 2010  | 2010/2010  |      |
|-----------------------|-------|-------|-------|-------|-------|------------|------|
|                       |       |       |       |       |       | Хувь зөрүү |      |
| Нийт тариалсан талбай | 162.0 | 202.7 | 192.5 | 282.2 | 315.3 | 111.7      | 33.1 |

<sup>6</sup> Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо. Газар тариалан.

|                   |       |       |       |       |       |       |      |
|-------------------|-------|-------|-------|-------|-------|-------|------|
| Үр тариа үүнээс:  | 126.2 | 121.8 | 154.0 | 252.4 | 259.2 | 102.7 | 6.8  |
| Буудай            | 117.9 | 116.7 | 150.0 | 248.9 | 250.2 | 100.5 | 1.3  |
| Төмс              | 10.7  | 11.5  | 12.3  | 13.5  | 13.8  | 102.2 | 0.3  |
| Хүнсний ногоо     | 5.9   | 6.1   | 6.4   | 6.5   | 7.0   | 107.7 | 0.5  |
| тэжээлийн ургамал | 3.9   | 4.9   | 5.5   | 3.3   | 11.1  | 336.4 | 7.8  |
| Техникийн ургамал | 15.3  | 58.4  | 14.3  | 6.2   | 23.3  | 375.8 | 17.1 |

ҮСХ-ны Газар тариалан

2010 оны тариалсан талбайг ургамлын нэр төрлөөр харвал: үр тарианы тариалсан талбай 2009 оныхоос 2.7 хувь буюу 6.8 мянган га-гаар, төмснийх 2.2 хувь буюу 0.3 мян.га-гаар, хүнсний ногооных 7.7 хувь буюу 0.5 мян.га-гаар, тэжээлийн ургамлынх 3.4 дахин буюу 7.8 мян.га-гаар, техникийн ургамлын тариалсан талбай 3.8 дахин буюу 17.1 мян.га-гаар нэмэгджээ. Мөн 2010 оны тариалсан талбайн бүтцийг авч үзвэл 82.2 хувийг үр тариа, 4.4 хувийг төмс, 2.2 хувийг хүнсний ногоо, 3.5 хувийг тэжээлийн ургамал, 7.4 хувийг техникийн ургамал эзэлж байна. Үүнийг 2009 оныхтой харьцуулахад нийт тариалсан талбайд тэжээлийн ургамлын эзлэх хувь 2.3 пунктээр, техникийн ургамлынх 5.2 пунктээр өсч, харин үр тариа, төмс, хүнсний ногооны талбай 0.1-7.2 пунктээр буурсан байна.

Тариалсан талбай аж ахуйн нэгж, байгууллагын төрлөөр

|                      | Үр тариа мян.га | Төмс мян.га | Хүнсний ногоо мян.га | Тэжээлийн ургамал мян.га | Эзлэх хувь |       |               |                   |
|----------------------|-----------------|-------------|----------------------|--------------------------|------------|-------|---------------|-------------------|
|                      |                 |             |                      |                          | Үр тариа   | Төмс  | Хүнсний ногоо | Тэжээлийн ургамал |
| ХАА-н компани хоршоо | 234.9           | 2.9         | 0.99                 | 5.5                      | 90.6       | 21.0  | 12.9          | 49.5              |
| Иргэд                | 24.3            | 10.99       | 6.1                  | 5.6                      | 9.4        | 79.0  | 87.1          | 50.5              |
| Бүгд                 | 259.2           | 13.8        | 7.0                  | 11.1                     | 100.0      | 100.0 | 100.0         | 100.0             |

Дээрх хүснэгтээс тариалалт хийсэн нийт талбайн бүтцийг харвал ХАА-н компани, хоршоонд үр тарианы талбайн 90.6 хувь, тэжээлийн ургамлын талбайн 49.5 хувь нь ногдож байгаа бол иргэд, өрхийн аж ахуйд төмсний талбайн 79.0 хувь, хүнсний ногооны 87.1 хувь, тэжээлийн ургамлын 50.5 хувь нь тус тус ногдож байна. Атрын аяны гурав дахь жилд 2010 онд тариалсан үр тарианы талбай Баянхонгор, Баян-Өлгий, Өвөрхангай, Увс, Дорнод, Орхон аймагт өмнөх оныхоос 1.5-5.5 дахин нэмэгдсэн байна. Тэжээлийн ургамлын тариалалт Архангай, Төв, Сүхбаатар, Хөвсгөл, Булган, Сэлэнгэ, Завхан аймагт 3.1-32.9 дахин нэмэгджээ. 2010 онд 276.5 мянга га талбайд уринш хийсэн нь 2009 оныхоос 2.8 хувиар буюу

7.4 мян.га-гаар их илүү байна. 2003-2007 онд жилд дунджаар нийт тариалсан талбайн 72.6 хувьд уринш хийж байсан бол 2010 онд тариалсан талбайн 87.7 хувьтай тэнцэх хэмжээний талбайд уринш хийжээ.

Монгол орны төвийн болон хангайн бүсэд будайн “Орхон”, “Дархан-34”, “Дархан-74”, “Бурятская-34”, “Бурятская-79”, “Халх гол-1” сортыг, баруун бүсэд “Халх гол-1”, “Цагаан дэглий” сортыг, зүүн бүсэд “Халх гол-1”, “Дархан-74” сортуудыг судлаач, эрдэмтдийн зөвлөмж болгосны дагуу голлон тариалжээ. Төмс тариалалт Дорнод, Ховд, Завхан, Дорноговь, Төв, Архангай, Баян-Өлгий, Улаанбаатар хотод 1.2-1.6 дахин өсч, Дундговь, Говь-Алтай, Өмнөговь аймгуудад 20.5-33.9 хувиар буурсан байна. “Монгол төмс” хөтөлбөрөөс хэрэгжүүлж буй судалгааны ажлын үр дүнд Голландын эрт болцтой “Импала” сорт, Германы дунд эртийн болцтой “Витара” сортыг нутагшсан сортоор сонгон тариалжээ.

## Хураасан ургац

|                   | 2006  | 2007  | 2008   | 2009  | 2010   | 2010/2009 |       |
|-------------------|-------|-------|--------|-------|--------|-----------|-------|
|                   |       |       |        |       |        | хувь      | зөрүү |
| Үр тариа          | 138.6 | 114.8 | 212.9  | 391.7 | 355.1  | 90.7      | -36.6 |
| Үүнээс буудай     | 127.8 | 109.6 | 209.8  | 388.1 | 345.5  | 89.0      | -42.6 |
| Төмс              | 109.1 | 114.5 | 134.8  | 151.2 | 168.0  | 111.1     | 16.8  |
| Хүнсний ногоо     | 70.4  | 76.4  | 78.6   | 78.0  | 82.3   | 105.5     | 4.3   |
| Хадлан            | 983.3 | 933.1 | 1031.0 | 912.3 | 1137.3 | 124.7     | 225.0 |
| Тэжээлийн ургамал | 10.2  | 8.1   | 19.9   | 10.4  | 34.8   | 335.9     | 24.4  |

ҮСТ.Газар тариалан

## Га-гийн ургац хүснэгт /цн/

|          | 2006  | 2007 | 2008  | 2009  | 2010  |
|----------|-------|------|-------|-------|-------|
| Үр тариа | 11.0  | 9.4  | 13.8  | 15.5  | 13.7  |
| Буудай   | 10.8  | 9.4  | 14.0  | 15.6  | 13.8  |
| Арвай    | 36.3  | 13.8 | 10.5  | 12.6  | 9.0   |
| Овьёос   | 14.8  | 8.4  | 11.0  | 10.7  | 12.8  |
| Төмс     | 101.7 | 99.9 | 109.6 | 111.8 | 121.6 |

2010 онд нэг га-гаас дунджаар 13.7цн үр тариа, үүнээс 13.8 цн буудай, 9.0 цн арвай, 12.8 цн овьёос, 121.6 цн төмс хураан авсан бөгөөд нэг га-гаас авсан ургац төмснийх 9.8 цн-р нэмэгдэж, үр тарианы 1.8 цн-р буурсан байна.

Монгол улс түүхэндээ 1985 онд хамгийн их буюу 886.2 мянган тн үр тариа хурааж байх үед нэг га-гаас дунджаар 13.9 цн үр тариа авч байсан дээд үзүүлэлт 2009 онд 15.5 болжээ. 2010 онд га-гаас хураан авсан үр тариа Төв, Дархан-Уул,

Архангай, Байян-Өлгий, Завхан аймагт 1.2-18.2 цн-ээр өсч, бусад үр тари а эрхэлдэг аймгуудад 0.7-12.8 цн-ээр буурсан байна.

Ургац хураалтын хэмжээг атрын I,II,III аяны дараа жил болон атрын гуравдугаар аяны өмнөх таван жилтэй зэрэгцүүлбэл /мян.тн/

|               | Атрын I аяны дараа жил | Атрын II аяны дараа жил | 2003-2007 оны дундаж | 2009  | 2010  | 2010/2003-2007 оны дундаж |       |
|---------------|------------------------|-------------------------|----------------------|-------|-------|---------------------------|-------|
|               |                        |                         |                      |       |       | хувь                      | зөрүү |
|               | 1962                   | 1979                    |                      |       |       |                           |       |
| Үр тариа      | 326.5                  | 360.5                   | 122.2                | 391.7 | 355.1 | 290.6                     | 232.9 |
| Төмс          | 23.9                   | 73.7                    | 91.7                 | 151.2 | 168.0 | 183.2                     | 76.3  |
| Хүнсний ногоо | 13.3                   | 26.8                    | 62.9                 | 78.0  | 82.3  | 130.8                     | 19.4  |

ҮСТ. Газар тариалан

Монгол улсын Засгийн газраас тариалан хөгжүүлэх Үндэсний хөтөлбөр “Атрын аян-III” хэрэгжүүлснээр 1990-ээд оноос хойш хураагаагүй арвин ургацыг 2009-2010 онд хураан улс орныхоо гурил, хүнсний хэрэгцээг дотооддоо үйлдвэрлэсэн ургацаар хангах нөхцлийг бүрдүүлжээ. 2010 онд хураан авсан ургацыг аяны өмнөх таван жилийн дундажтай харьцуулбал хураасан үр тариа 2.9 дахин буюу 232.9 мянган тн, төмс 1.8 дахин буюу 76.3 мянган тн, хүнсний ногоо 1.3 дахин буюу 19.4 мянган тн-р өссөн байна. Ингэснээр жилийн хэрэгцээт буудай, төмсийг 100 хувь, хүнсний ногооны 53,7 хувийг дотоодоос хангах болсон байна.

Ийнхүү газар тариалан хөгжүүлэх үндэсний хөтөлбөр Атрын аян-III-ыг өрнүүлснээр

- Тариалангийн салбарт техник, технологийн шинэчлэлийн хүрээнд зүтгэх хүчний техникийг 60%, ургац хураах техникийг 55% шинэчилжээ.

- Усалгаатай тариалангийн га талбайг нэмэгдүүлжээ.

Усалгаатай тариалангийн тоон үзүүлэлт

| Үзүүлэлт                                      | 2012   | 2013   | 2014   | 2015  |
|---|--------|--------|--------|-------|
| Тухайн онд нэмэгдсэн усалгаатай тариалан / га | 50900  | 53368  | 54042  | 54122 |
| Усалалтын системийн тоо                       | 28     | 10     | 7      | 1     |
| Улсын төсвийн хөрөнгө оруулалт сая төг.       | 4600.0 | 5600.0 | 2800.0 | 127.0 |

- Стратегийн зориулалтаар хүнсний улаан буудайн нөөц бүрдүүлэх, хадгалах, хамгаалах технологийг сайжруулах зорилгоор 36,0 мянган тн багтаамжтай

элеваторын Төв, Булган аймагт засварлаж ашиглалтад оруулсан бол Сэлэнгэ аймагт 10,0 мянган тн багтаамжтай элеваторыг шинээр ашиглалтад оруулжээ. Дархан-Уул аймагт үр тариа хадгалах зориулалттай 36.0 мянган тонн багтаамжтай төмөр бетон элеватор худалдан авах тендер шалгаруулалтыг зохион байгуулж, элеваторыг 2015 оны 04 дүгээр сард ашиглалтад хүлээн авч Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн харъяа “Дархансалбар”-ыг байгуулжээ.

- “Буудайн элит үргаргах, үржүүлэх” төслийг 2014 оноос БНСУ-ын КОПИА-Монгол төвийн 165.000 ам.долларын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр Дархан-Уул аймгийн Ургамал газар тариалангийн хүрээлэн хэрэгжүүлжээ. Төслийн дүнд Монгол оронд нутагшсан 4 сортын элит үр үйлдвэрлэх эх материал ганцаарчилсан ба бөөний сонголтын аргаар 15.3 тн бий болгон супер элит үр 47.3 тн, элит үр 22.5 тонныг тус тус үйлдвэрлэн шинэ сортуудыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх эх үрийг бий болгожээ. Төслийн үр дүнгээс харахад Дархан-144, Дархан-131, Дархан-166, Дархан-34 сортууд нь хяналтаас 1.8-1.9 ц/га-аар нэмүү ургац өгч, 1 га-аас 1500,0 мян/ төгрөгийн ашигтай байгааг харуулсан байна. Төслийг хэрэгжүүлснээр элит үрийн тариалалтыг 10 хувиар нэмэгдүүлэх боломж бүрдэж байна. Улсын хэмжээнд импортоор оруулж байгаа үрийг 20 хувиар багасгах боломж бүрджээ.

#### Буудайн үр үйлдвэрлэл, хангамж

| Үзүүлэлт                                   | 2012 | 2013 | 2014 | 2015 | 2016  |
|--|------|------|------|------|-------|
| Улсын төсвийн хөрөнгө оруулалт сая төг     | -    | -    | 55   | -    | -     |
| Буудайн үр үржүүлэх ААН-ийн тоо            | 13   | 3    | 4    | 5    | 5     |
| Ирээдүйтэй сорт                            | 2    | -    | 1    | 1    | 1     |
| Нутагшсан сорт                             | 3    | -    | 1    | -    | 1     |
| Буудайн үрийн хангамж хувь                 | 60.0 | 60   | 100  | 100  | 60.0  |
| Дотоодод үржүүлсэн үр тонн                 | 175  | 250  | 180  | 165  | 250   |
| Импортын үр                                | 1200 | 6400 | 1200 | 14   | 20000 |
| ТЭДС, Улсын нөөцийн газраас олгосон үр, тн | 2800 | 3000 | 9200 | 7800 | -     |
| Үр хүлээн авсан ААН-ийн тоо                | 126  | 98   | 298  | 340  |       |

- Төмс, хүнсний ногооны үр үржүүлэг, сорт, сорилт, үйлдвэрлэлийн тогтолцоог шинэчлэн зохион байгуулжээ. 2013 оны төсвийн 198.0 сая төгрөгөөр “Сорт сорилтын төвүүдийн үйл ажиллагааг сэргээх ТЭЗҮ боловсруулсан байна. Сэлэнгэ аймгийн Найрамдал, Сайхан сумд, Хөвсгөл аймгийн Тариалан сум, Төв аймгийн Борнуур сумын сорт сорилтын салбарын үйл ажиллагааг сэргээжээ. Дархан -Уул, Төв, Хөвсгөл, Сэлэнгэ аймгууд дахь Сорт, сорилтын төвүүд болон лабораторийг өөрчлөн зохион байгуулжээ. Үр үржүүлэг, сорт сорилтын төв байгуулах талаар “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар

баримтлах бодлого” -д тусгажээ. Улсын сорт сорилтын зөвлөлийн 70.0 43 хуралдаанаар хүнсний ногооны 6 сортыг ирээдүйтэй, 2 сортыг нутагшсан сортоор батлуулж үйлдвэрлэлд нэвтрүүлэв. Төл сонгины 7 тонн үрийг импортоор авч үр үржүүлсэн байна.

Хүнсний ногооны үр үйлдвэрлэл, хангамж

| Үзүүлэлт                                  | 2012 | 2013  | 2014  | 2015 | 2016  |
|---|------|-------|-------|------|-------|
| Улсын төсвийн хөрөнгө оруулалт, сая төг   | 45.5 | 146.0 | 120.0 | 80.0 | 120.0 |
| Хүнсний ногооны үр үржүүлгийн ААН-ийн тоо | 12   | 17    | 19    | 21   |       |
| Ирээдүйтэй сорт                           | 6    | 11    | 17    | 6    |       |
| Нутагшсан сорт                            | -    | -     | -     | 2    |       |
| Хүнсний ногооны үрийн хангамж, хувь       | 50.0 | 37.5  | 37.5  | 46.8 |       |
| Дотоодод үржүүлсэн үр, тонн               | 8.0  | 6.0   | 6.0   | 7.5  |       |
| Импортын үр, тонн                         | -    | 40.0  | 10.0  | 7.0  |       |

2015 оны байдлаар төмсний албан бус үр үржүүлэгч 300 иргэн, аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж, төмсний үрээр дотоодын хэрэгцээг бүрэн хангаж байв. Улсын сорт сорилтын зөвлөлийн хуралдаанаар төмсний 2 сортыг ирээдүйтэй сортоор батлуулж үйлдвэрлэлд нэвтрүүлэв.

Төмсний үр үйлдвэрлэл, хангамж

| Үзүүлэлт                                | 2012  | 2013 | 2014 | 2015 | 2016 |
|---|-------|------|------|------|------|
| Улсын төсвийн хөрөнгө оруулалт, сая төг | 60.0  | -    | -    | -    | 80.0 |
| Төмсний үр үржүүлгийн ААН-ийн тоо       | 160   | 190  | 230  | 300  |      |
| Ирээдүйтэй сорт                         | 3     | 2    | 1    | 2    |      |
| Нутагшсан сорт                          | 3     | 3    | -    | -    |      |
| Төмсний үрийн хангамж, хувь             | 80    | 100  | 100  | 100  |      |
| Дотоодод үржүүлсэн үр, тонн             | 40.0  | 34.5 | 33.2 | 35.0 |      |
| Импортын үр, тонн                       | 143.8 | 0.09 | -    | -    |      |

- Монгол улсын Засгийн газрын 2010 оны 60 дугаар тогтоолоор “Чацаргана” үндэсний хөтөлбөрийг батлан жимс, жимсгэний салбарын хөгжлийг дэмжихэд чиглэсэн эрх зүй, эдийн засгийн таатай орчин бүрдүүлэх, тариалалт, боловсруулалтын технологийг боловсронгуй болгох арга хэмжээ авч чацаргана болон бусад жимс жимсгэнэ тариалан түүнийг боловсруулах үйлдвэрүүдийг байгуулан экспортын орлогыг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох зорилтуудыг дэвшүүлэн тавьсан. 2010-2013 онд 5.6 тэрбум төгрөгийн 2.636.0 мянган ширхэг чацарганы суулгац, 60.0 мянган ширхэг гүзээлзгэний суулгацыг дотоодын суулгац үржүүлэгч аж ахуйн нэгжүүдээс худалдан авч төсөл сонгон шалгаруулан 22 аймгийн 2000 гаруй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад 5 жилийн хугацаатай



зээлээр олгон жимс жимсгэнийн талбайг 2100 га талбайгаар нэмэгдүүлжээ. Увс аймгийн “Увс хүнс” ХК-д 400.0 сая төгрөгийн зээлийн дэмжлэг үзүүлж жилд 1500 тонн, Улаанбаатар хотод Живэртийн оргил ХХК-ийн “Шар доктор” үйлдвэрт 700.0 сая төгрөгийн зээлийн дэмжлэг үзүүлж жилд 1500 тонн чацаргана боловсруулах үйлдвэрүүдийг байгуулан ашиглалтад оруулсан ба хувийн хөрөнгө оруулалтаар Витафит ХХК, Тэсо групп ХХК, Хаан жимс эс би Ти ХХК-ийн “Хуба хаяа” зэрэг 20 гаруй жижиг, дунд хүчин чадлын үйлдвэр шинээр ашиглалтад орж жилд 9600 тонн чацаргана, жимс жимсгэнэ боловсруулах хүчин чадал бүхий 52 боловсруулах үйлдвэрүүд бий болжээ. Алим, чавга, интоор, бөөрөлзгөнө, гүзээлзгэнэ, үхрийн нүд зэрэг бага тархацтай, Монголд ургах боломжтой жимс жимсгэнийн тариалалтыг нэмэгдүүлэх зорилгоор 2013 онд “Жимс жимсгэний аж ахуй байгуулахад дэмжлэг үзүүлэх” төсөл шалгаруулалт зохион байгуулан 74 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг шалгаруулан нийт 2.3 тэрбум төгрөгийн жилийн 2.4 хувийн хүүтэй 5 жилийн хугацаатай зээл олгож жимст цэцэрлэгийн талбай 150.0 га-гаар нэмэгдүүлэв. 2014 онд Монгол чацарганын үнэ цэнийг бий болгож, экспортод гаргах болжээ. Тухайлбал Сийбэрри ХХК зөөлөн эдийн тос, хатаасан навч, жимсийг БНСУ-д экспортлож гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэн АНУ, БНСУ, Япон, Сингапур, Малайз зэрэг 6 оронд борлуулж байна. Увс хүнс ХК үрийн болон зөөлөн эдийн чацарганы тосыг БНСУ, АНУ, Тайвань улсад гаргаж эхэлсэн бол, Живэртийн оргил ХХК Япон улс руу тос, шүүс, Витафит ХХК Япон, Солонгос улсад чацаргана, нэрсний шүүс экспортлох болжээ.

- Тэг болон цомхотгосон технологиор боловсруулсан уриншийн эзлэх хувийг нэмэгдүүлсэн байна. 2012 онд 316.9 мянган га талбайд уринш бэлтгэснээс 148.4 мянган га талбайд химийн уринш хийсэн бол 2015 онд 335.8 мянган га -д чанар сайтай уринш боловсруулж бэлтгэснээс 141.3 мянган га талбайд химийн уринш хийжээ. Уринш бэлтгэлийн ажилд зориулан аж ахуйн нэгж, иргэнд дизелийн түлшийг 50 хувийн урьдчилгаа нөхцөлтэйгээр, ургацын чанарыг сайжруулах, өвчин хортонтой тэмцэх ажлын хүрээнд аж ахуйн нэгжид ургамал хамгааллын бодис, гербицид, эрдэс бордоог 30 хувийн урьдчилгаа нөхцөлтэйгээр тус тус гэрээ байгуулан зээлээр олгожээ. Тэг элдэншүүлгийн технологи нэвтрүүлэх төсөл сонгон шалгаруулалт явуулж өндөр хүчин чадлын трактор үрлэгчийн 10 иж бүрдэл, ургамал хамгааллын бодис цацагч 4 -ийг худалдан авахад зориулж 13 аж ахуйн нэгжид 5.5 тэрбум төгрөгийн зээлийн дэмжлэг үзүүлэв. Дээрх техникээр 23.6 мянган га талбайд үрлэгээ, 7.8 мянган га талбайд химийн уринш хийх

боломж бүрдүүлэв. Ойролцоогоор 140 мянган тонн бордоо жилд шаардлагатай бөгөөд 2015 онд 2 үйлдвэр шинээр байгуулж, 23760 тонн бордоо үйлдвэрлэснээр бордооны хангамж 20 хувьд хүрсэн.

Уринш боловсруулалт

| Үзүүлэлт                                 | 2012  | 2013  | 2014  | 2015  |
|--|-------|-------|-------|-------|
| Нийт уринш, мянган га                    | 316.9 | 311.1 | 337.2 | 335.8 |
| Химийн урхинш, мянган га                 | 148.4 | 135.0 | 133.9 | 141.3 |
| Химийн уриншийн нийт уриншинд эзлэх хувь | 46.8  | 43.4  | 39.7  | 42.1  |

Уринш бэлтгэлд үзүүлсэн дэмжлэг

| Үзүүлэлт  | 2012   | 2013   | 2014  | 2015  |
|---|--------|--------|-------|-------|
| Дизель түлш, тонн                               | 1685   | 4027   | 4741  | 4300  |
| Түлш авсан ААН                                  | 609    | 1118   | 1236  | 1050  |
| Ургамал хамгааллын бодис, гербицид, мянган литр | 574    | 370    | 432   | 415.1 |
| Ургамал хамгааллын бодис авсан ААН              | 367    | 702    | 666   | 514   |
| Эрдэс бордоо, тонн                              | 551,75 | 419,85 | 215.0 | 998.9 |
| Эрдэс бордоо авсан ААН                          | 53     | 57     | 17    | 41    |

- Ойн зурвас байгуулах, хашаажуулах замаар тариалангийн талбайн хөрсийг элэгдэл, эвдрэлээс хамгаалж, үржил шимийг сайжруулахад анхаарч 20000-аас доошгүй га -д ойн зурвас байгуулсан байна. Ойн зурвас байгуулах арга хэмжээний хүрээнд 21 аймгийн 326 байгууллага, 1303 аж ахуйн нэгж, 18116 иргэн бүртгэлд хамрагдаж ойн зурвас болон хашаажуулах ажлыг гүйцэтгэсэн. Төв аймгийн Архуст сумын “Хишигтэн нүүдэлчин” компани 2000 ширхэг мод тариалан ойн зурвас байгуулж өөрийн эзэмшлийн 4000га талбайн хөрсийг салхины элэгдэл, эвдрэлээс хамгаалав. Мөн “Чацаргана хөтөлбөр” -ийн хүрээнд нийт 2.5 сая ширхэг чацарганы суулгацыг иргэн, аж ахуйн нэгжүүдэд зээлээр олгон улсын хэмжээнд 20000 га талбайн хөрсийг элэгдэл эвдрэлээс хамгаалах нөхцөл бүрдсэн.

- Цогцолбор аж ахуйг түшиглэн малын тэжээлийн үйлдвэр, цехийг шинээр барьж байгуулсан байна.Монгол орны нөхцөлд ойролцоогоор 140 мянган тонн бордоо жилд шаардлагатай бөгөөд 2015 онд 2 үйлдвэр шинээр байгуулж, 23760 тонн бордоо үйлдвэрлэснээр бордооны хангамж 20 хувьд хүрсэн. “Минерал Агро” ХХК нь Багануур дүүрэгт хоногт 60 тонн бордоо үйлдвэрлэх хүчин чадал бүхий 3.0 орчим тэрбум төгрөгийн өртөгтэй үйлдвэрийг байгуулжээ. Тус үйлдвэр нь бууц, шувууны сангас, органик хүнс, ногооны үлдэгдэл ашиглан органик бордоо, азот фосфор, кали гэх эрдэс бордоо мөн түүн дээр яс, нүүрс нэмэн нийлмэл бордоо үйлдвэрлэнэ. Тус үйлдвэр 2015 оны хаврын тариалалтад зориулан 1500 тонн 25

хувийн нүүрс, ястай азотын бордоо, 50 тонн органик бордоо үйлдвэрлэжээ. Мөн “Хийрэв”, “Монгол экологийн бордоо”, Хастав” зэрэг ХХК –иудхүчин чадлаа нэмэгдүүлсэн байна. Жилд 51.1 мянган тонн бордоо үйлдвэрлэх үйлдвэр Төв аймгийн Баянчандмань суманд, 21.9 мянган тонн бордоо үйлдвэрлэх үйлдвэр Улаанбаатар хотын Багануур дүүрэгт 2016 онд тус тус ашиглалтад оржээ. Ингэснээр жилийн хэрэгцээт бордооны 50 хувийг дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой болжээ.

-Газар тариалан, фермерийн бүс нутгийг түшиглэн хуурай сүү боловсруулах үйлдвэр, аймгуудад цөцгийн тос болон сүүн бүтээгдэхүүний үйлдвэр байгуулахыг дэмжих Засгийн газрын 2013 оны 141 дүгээр тогтоол гарч, Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжихэд зориулж 27.7 сая ам.долларын хөрөнгө оруулалтын зээлийг олгохоор шийдвэрлэжээ. “Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл” төслийн хүрээнд Голомт банкнаас нийт 47 төсөлд нийт 38.5 тэрбум төгрөгийн зээл батлагдаж 44 төсөлд 29.4 тэрбум төгрөгийн зээл олгогджээ. Үүнээс эрчимжсэн мал аж ахуйн 24 төсөлд 18.7 тэрбум төгрөгийн зээл олгосон байна. Төсөл эхэлснээс хойш Франц, Герман, Словак улсуудаас өндөр ашиг шимтэй Симменталь болон Монтебелиард, 90.0 12 Хартарлан, Швейцын бор үүлдрийн 920 үхэр импортолж Төв аймгийн Архуст, Баян, Баянчандмань, Сэлэнгэ аймгийн Мандал сумдад нутагшуулан үржүүлж байна. Дээрх дэмжлэгийг олгосноор сүүний чиглэлийн үхрийн аж ахуй, түүнд өсгөн үржүүлж буй үхрийн тоо толгой жил бүр өссөн дүнтэй байна. Улсын хэмжээнд 200-аас дээш сүүний чиглэлийн үхэртэй цогцолбор аж ахуй 15 байна.

-Тариалангийн бүсэд гахайн цогцолбор аж ахуй хөгжүүлэхэд зээлийн дэмжлэг үзүүлж, гахайн мах үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ Гахайн аж ахуй эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор 2012 -2015 онд 51 иргэн, аж ахуй нэгжид 839.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг Мал хамгаалах сангаар дамжуулан олгов. Улсын хэмжээнд 2015 оны жилийн эцсийн урьдчилсан мэдээгээр 331 иргэн, аж ахуйд 29946 толгой гахай өсгөн үржүүлж байна. Гахайн Гаалийн ерөнхий газрын статистик мэдээгээр 2015 оны байдлаар 1795.6 тонн гахайн мах импортолсон нь өмнөх оны мөн үеийнхээс 9.4 хувиар буурсан байна. Түүнчлэн Монголбанкны Ерөнхийлөгч, ҮХАА -н сайдын хамтарсан 2012 оны А/166 -А/24 дугаар тушаалаар батлагдсан “Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийн хүрээнд “Мах, мах-сүүний чиглэлийн үхрийн, махны чиглэлийн хонь, гахай, тахианы цогцолбор аж ахуйг шинээр байгуулах, өргөжүүлэх” төсөл

сонгон шалгаруулж 2014 онд шувууны аж ахуй эрхэлдэг 3 аж ахуйн нэгжид 8.6 тэрбум төгрөгийн зээлийн дэмжлэг үзүүлэв. 2014 онд өмнөх онтой харьцуулахад баруун бус болон нийслэлд тахианы тоо буурч, хангай, төв болон зүүн бүсийн тахиан тоо нэмэгдсэн байна.

## **Abstract**

### **Третье освоение целины, его особенность и результаты**

**Ключевые слова:** освоение земли, рынок, агротехника, земледелие

По переходу в рыночную систему в 1990 году сельскохозяйственное производство и прежний темп удовлетворения продовольственной потребности тормозились. Ибо стала хромать взаимосвязь организации работы, подготовки и пополнения кадрами, технического обслуживания, обновления и доставки горючих и других главных работ, стали организовывать весенние и осенние пашни без соответствующих агротехнических требований и увеличили эрозию почвы вследствие приватизации государственных предприятий и больших государственных сельскохозяйственных хозяйств со спешкой, без подготовки, вычисления и исследования.

Кроме того, интенсивное изменение климата в масштабе мира в последние годы влияло на эко систему и грозит продовольственному снабжению и безопасности населения. Наряду с этим увеличение цены на нефть приводит к дефициту энергии, тенденция производить биотопливо из выращиваемой культуры появилась в развитых странах, что привела к запрету стран, которые экспортируют пшеницы и резкому увеличению цены на зерно и муку.

В такой ситуации в постановлении №70, выдвинутом правительством Монголии в 2008 году была поставлена цель обработать национальную программу развития земледелия “III освоение целины”, создать юридическо-экономическую среду для сельскохозяйственной промышленности, повысить знание и способность земледельцев, подготовить специалистов, увеличить площадь полей путем введения в использование паров и ускорить сельскохозяйственное производство.

Особенностью третьего освоения целины является его достижение успеха в период рыночной экономики, если первое и второе освоения целины были организованы в период социализма.

Политику монгольского правительства и ее реализацию по земледелию с 1990 года можно рассмотреть по следующим этапам:

1. Сельскохозяйственное производство было поддержано в рамках разных проектов с 1998 года по 2005 год.

2. Национальная программа по развитию земледелия была разработана и реализована с 2006 года по 2011 год
3. Реализация Национальной программы “Про освоение целины” продолжалась с 2012 года по 2015 год.

Комплексные проекты по развитию сельского хозяйства национального масштаба были разработаны и реализованы с 2016 по 2019 год.

#### **Ном зүй**

1. *Атар 50: Ололт, тулгамдсан асуудал, шийдвэрлэх зорилт.* Онол үйлдвэрлэлийн бага хурлын илтгэлийн эмхтгэл. Улаанбаатар, 2009.
2. *Атрын гурав дахь аян хөтөлбөрийн талаар юу мэдэх вэ?.* Улаанбаатар, 2008.
3. *Атрын гурав дахь аян Үндэсний хөтөлбөрийн төгсгөлийн шатны хяналт шинжилгээ, үнэлгээний тайлан.* Улаанбаатар, 2011.
4. Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо. *Газар тариалан.*
5. УТА. Х-15. Д-5. ХН-350.
6. УТА. Х-15. Д-5. ХН.465.
7. УТА. Х-15, Д-5, ХН-467.